

“НҮҮДЭЛЧИН”

ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬД ДАРХАН-УУЛ АЙМГААС ОРОЛЦСОН ТАЙЛАН



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР
2023 ОН

Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.6 дахь заалт “Соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах чиглэлээр олон улсын арга хэмжээг зохион байгуулна”, 3.4.5.1 дэх заалт “Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж цар хүрээг өргөжүүлэх”, Засгийн газрын 2023 оны 264 дүгээр тогтоолоор 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг 2023 оны 08 дугаар сард зохион байгуулах тухай” Монгол улсын Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн дугаар 183 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас ирүүлсэн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/253 тоот “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох тухай албан бичиг, удирдамжийг үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс 21-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн “Тайж хайрхан”-ы бэлд Дархан-Уул аймаг нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.



Зураг 1-2. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд Дархан-Уул аймгаас оролцсон бүрэлдэхүүн /2023.08.16-21/

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01-А/163 дугаар захирамжаар “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох, зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах ажлыг хэсгийг аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлангаар ахлуулан 16 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулав. Улмаар бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж Соёлын байгууллагууд, аймаг сумдын ЗДТГ болон холбогдох байгууллагуудад албажуулан хүргүүлж ажилласан.

2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр соёлын байгууллагуудын удирдлагуудад “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох бэлтгэл ажил, зохион байгуулалтын талаар аймгийн Соёл, урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ чиглэл өгөв. Хуралд Музейн дарга Д.Жамбалдорж, Залуучууд театрын Уран сайхны удирдаач Г.Саранчимэг, Хүүхдийн номын ордны дарга Л.Мөнхбаатар нар оролцов.

Тус наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн хоёр дахь хурлыг 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зохион байгуулж удирдамж бэлтгэл ажлын төлөвлөгөөг танилцууллаа.



Зураг 3-6. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуралдсан нь. /2023.06.21, 2023.08.08/

Ажлын хэсгийн хуралд “Нүүдэлчин” соёлын фестивальд оролцох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн дарга бөгөөд аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан, нарийн бичгийн дарга бөгөөд Соёл, урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ, гишүүд болох Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Дархан, Орхон, Хонгор сумдын Засаг дарга, тамгын газрын дарга нар, Соёлын төвийн дарга нар, Залуучууд театр, аймгийн Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, аймгийн Нийтлэг үйлчилгээний алба, аймгийн Зураач урчуудын эвлэлийн төлөөлөгчид танхим болон цахимаар оролцлоо.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас зарласан цахим хурлуудад аймгийн Соёл, урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ тогтмол оролцож мэдээ, мэдээллийг цаг тухайд нь авч холбогдох зохион байгуулалтыг хийж ажилласан.

Удирдамжид заасан нэгдсэн төлөвлөлт, зургийн дагуу 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Улаанбаатар хотын Налайх дүүрэгт байрлах Тайж хайрханы бэлд их найман ханатай 1 том гэр, зургаан ханатай 3 гэрийг барьж, Дархан-Уул аймгийн отгийг байгуулсан. Отгийн гадна зохион байгуулалт, тохижилтыг ажлын хэсгээс өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Залуучууд театрын зураач Г.Хашцэцэг хариуцан ажиллалаа.

Отгийн гадна талбайд сур элдэх, ноос савж эсгий хийх, утас ээрэх, ааруул эзгий боловсруулах, гурил тээрэмдэх, үхэр тэрэг, нүүдэл зэрэг монгол ахуйгаа дэглэж үзэгч олонд сурталчлан таниулав. Отгоо тохижуулахдаа уламжлал шинэчлэлийг хослуулан аж үйлдвэр, дэд бүтэц эрчимтэй хөгжсөн залуу хотын онцлогийг харуулахыг зорьж, Дарханы тугаар мэндчилсэн Төмөр хүнээр угтуулж найрамдан эвлэлдэхийн утгыг бэлгэдэж, Хаан бугуйвчаа хоймортоо байрлуулсан. "Хаан бугуйвч" нь Дархан хотын эрхэмлэн дээдэлдэг бэлгэ тэмдэг бөгөөд түүнийг хэрэглэх журмыг анх Хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн 1974 оны 95 дугаар тогтоолоор баталж байсан түүхтэй.

Отгогт ажиллах нийгмийн хэв журам сахиулах байгууллагуудаас тогтоосон дүрэм журмыг мөрдөж байрласан.



Зураг 7-8. Дархан-Уул аймгийн отгийн харагдах байдал

Дархан-Уул аймгаас 5 ай савын соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч 9, уламжлалт гар урлал ай савд соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч 6, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн асарт 4 оролцогч 11 байгууллагын 100 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр, удирдлага зохион байгуулалт 4 нийт 42 оролцогч, арын албаны зохион байгуулах 16 нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.

Соёлын өвийн орон зай, бүтээлч үйлдвэрлэл, уламжлал шинэчлэл, баялаг байдал, соёлын биет бус өвийн олон төрөл зүйлийг түгээн дэлгэрүүлэх, илэрхийлэх хэлбэр, язгуур өв соёлоо дээдэлж, зохион байгуулалттай оролцсон, таниулан сурталчлахад амжилттай оролцсон “**ШИЛДЭГ 5 АЙМГИЙН НЭГ**”-ээр шалгарч, цом батламж гардан авлаа.



Зураг 9-10. Шагнал гардуулах ёслолын үеэр /2023.08.20 19.00 цаг/

Ардын язгуур урлагийн тоглолтод мэргэжлийн урлагийн байгууллага буюу Залуучууд театрын 20 уран бүтээлч болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэлд бүртгэгдсэн Баяд, Хотон бий биелгээ, Икэл хөгжим тоглох урлаг, Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг өвөөр соёлын биет бус өвийн 3 өвлөн уламжлагч оролцлоо. Мөн соёлын биет бус өвлөн уламжлагч **Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд ай савд** Хурдан морины Цол дуудлага, Гийнгоо, марзай, Ерөөл, Магтаал, уртын дуу өвөөр аав, хүү зэрэг соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчид оролцсон юм.

Ардын язгуур урлагийн оролцогчид тайзны бие даасан тоглолтыг 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр толилуулж, бусад өдрүүдэд отгийн тоглолтыг хуваарийн дагуу тоглов. Мөн нэгдсэн гала тоглолтод “Элхэндэг” бүжгээр оролцож, дуучин Б.Амархүүгийн “Монгол наадам” дуунд бүжигчид, өвлөн уламжлагч нар бий биелж, “Хүслийн төвөргөөн” хөгжмийн тоглолтод хөгжимчид хамтран хөгжимдөв.

Дархан-Уул аймаг

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль
2023 он

Ардын язгуур урлагийн тоглолтын найруулагчаар Залуучууд театрын Уран сайхны удирдаач Г.Саранчимэг ажиллав.



Зураг 11-12. Дархан-Уул аймгийн тайзны болон отгийн язгуур урлагийн үзүүлбэрийн үеэр /2023.08.18-20/



Зураг 13-14. Тайзны тоглолт /2023.08.18/



Зураг 15-16. Тайзны гала тоглолт /2023.08.20/



Зураг 17-18. Дуучин Б.Амархүүгийн “Монгол наадам” дуунд бүжигчид, өвлөн уламжлагч нар бий биелж байгаа нь /2023.08.20/

Ардын язгуур урлагийн төрөлд:

Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд болон ардын язгуур урлагийн ай савын төрөлд Хонгор сумын иргэн, Монгол Улсын Үндэсний өв соёл цоллоочдын холбооны тэргүүн, Улсын морь, бөх цоллооч, МУСТА, Ерөөлч магтаалч, соёлын биет бус өвийн 3 дахь үеийн өвлөн уламжлагч Б.Дарханням, хүү Д.Гантөгсийн хамт оролцлоо.



Зураг 19-20. Аав, хүү өвлөн уламжлагчид отгийн язгуур урлагийн тоглолтын үеэр

Ардын язгуур урлагийн ай савын Яаралтай хамгаалах соёлын биет бус өвийн бүртгэлд бүртгэгдсэн Хотон бий биелгээний өвөөр Дархан сумын ахмад настан СББӨ -ийн өвлөн уламжлагч, Ардын авьяастан 8 дахь үеийн өвлөн уламжлагч Б.Таамж, дүү Икэл хуур, Морин хуур хөгжмийн уламжлалт урлагийн өвлөн уламжлагч, Ардын урлагийн наадмын Тэргүүн байр, Ардын язгуур урлагийн мөнгөн медальт, Тэргүүний Ардын авьяастан 4 дэхь үеийн өвлөн уламжлагч Б.Бааст, ач охин Соёлмаа нарынхаа хамт Нүүдэлчин дэлхийн соёлын фестивальд оролцлоо.



Зураг 21-24. Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч ах Б.Таамж, дүү Б.Бааст, зээ Н.Соёлмаа нар гэр бүлээрээ оролцсон нь

Ардын язгуур урлагийн ай савын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэлд бүртгэгдсэн Баяд бий биелгээний өвөөр Дархан-Уул аймгаас оролцогч Алтангадас одонт, Ардын авьяастан, Баядын алдарт бийч Жамъян гуайн охин, 4 дэхь үеийн өвлөн уламжлагч Ж.Дэжидмаа Монголчуудын эрт үеэс уламжлагдан ирсэн Гал тахих зан үйлийг илэрхийлсэн “Галын мөргөл” бий биелгээгээр оролцлоо.



Зураг 25-26. Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч Ж.Дэжидмаа бий биелж байгаа нь

Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага ай савын Морьт харвааны өвийн төрлөөр Орхон сумын малчин, Морин спортын мастер, 2000 км-ын холын зайн морин уралдааныг 39 цаг 36 мин 23 секундын хугацаанд туулсан рекорд эзэмшигч, Бүх ард түмний долдугаар их наадмын алтан медальт, Биеийн тамирын тэргүүний ажилтан СББӨ-ийн өвлөн уламжлагч Б.Түмэннаст оролцлоо. Тэрээр Монголын анхны мастер эмэгтэй морьт харваач юм.



Зураг 27-28. Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч Б.Түмэннаст оролцсон нь.

Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл ай савын Байгаль хамгаалах уламжлалт арга мэдлэг, зан үйл, **Уламжлалт арга ухаан ай савын** Бариа заслын аргаар анагаах арга ухаан, Мал, амьтны эд эрхтнээр анагаах арга ухаан, Ургамлын зүйлээр анагаах арга ухаан, Дом, шившлэгийн аргаар анагаах арга ухаан, Зүү тавих арга ухаан, Төөнүүр хийх арга ухаан, Тан бэлдэх арга ухаан, Гүрэм домын арга ухаан Язгуур шүтлэгийн ёс, зан үйл, Уул овоо тахих монгол зан үйл зэрэг өвөөр СББӨ-ийн өвлөн уламжлагч О.Туул оролцлоо.



Зураг 27-28. Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч О.Туул оролцсон нь.

Уламжлалт арга ухаан ай савын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэлд бүртгэгдсэн Нохойгоор ан хийх, сургах өвийн төрлөөр Дархан сумын СББӨ 7 дахь үеийн уламжлагч А.Нямпүрэв, хүү өвлөн уламжлагч Н.Үйтүмэнтэйгээ хамт монгол банхар 3, тайга нохойтой оролцлоо.



Зураг 29-32.СББӨ-ийн өвлөн уламжлагч А.Нямпүрэв, Хүү Н.Үйтүмэнгийн хамт

Уламжлалт арга ухааны ай савын Угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг төрлөөр Дархан сумын өндөр настан, Алтан гадас одонт, СББӨ-ийн өвлөн уламжлагч Г.Мягмар оролцлоо. Тэрээр 1919-2019 оны хоорондох угийн бичээсийг танилцуулсан бөгөөд угийн бичээсээ аав С.Гэмбэл, С.Гэндэнжав нараас өвлөн уламжилсан байна.



Зураг 33-34. Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч Г.Мягмар бүтээлээрээ оролцсон нь.

Уламжлалт гар урлалын ай савын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэлд бүртгэгдсэн Ном бүтээх уламжлалт урлалын төрлөөр Дархан сумын иргэн, Боловсролын тэргүүний ажилтан, Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч, 2022 оны Нүүдэлчин монгол соёлын наадмын Шилдэг өвлөн уламжлагч Ж.Эрхэмсайхан оролцлоо.

Тэрээр эртний түүхт хуйлмал номыг урлан нүүдэлчин монголчууддаа дэлгэн танилцуулж, мянган жилийн буурал түүхтэй монгол бичиг соёлыг судлах сургалтын хөтөлбөрийг боловсруулснаа танилцуулсан юм.



Зураг 35-36. Шилдэг өвлөн уламжлагч Ж.Эрхэмсайхан бүтээлээ дэлгэсэн нь.

Уламжлалт гар урлалын ай савын Монгол зургийн урлал, Шуумлын урлал, Монголын уламжлалт модон эдлэлийн урлалын төрлүүдээр Дарханы Зураач урчуудын эвлэлийн тэргүүн, Монгол улсын Соёлын тэргүүний ажилтан, Монгол зураач Н.Хишигбаатар оролцлоо.

2016 оноос Дарханы урчуудын эвлэлийн Тэргүүнээр сонгогдон ажиллаж байгаа тэрээр 2017 онд БНХАУ-д Монгол туургатны түүхэн 108 метр урт зургийг, мөн Дархан хот дахь Найрамдлын өндөрлөг хөшөө, Дарханы сүлд дууны хөшөө зэрэг томоохон бүтээлүүдийг урлах ажлыг удирдан гүйцэтгэсэн юм.



Зураг 37-40. Дарханы Зураач урчуудын эвлэлийн тэргүүн, Монгол зураач Н.Хишигбаатар бүтээлээрээ оролцсон нь.

Уламжлалт гар урлалын ай савын Баримлын урлал, Монгол дарханы уламжлалт арга ухаан өвөөр Д.Энхболд “Шүтээн” бүтээлээрээ оролцлоо. Тэрээр алт, мөнгөний дархан, арьс, ясан эдлэлийн бүтээл туурвихаас гадна Улан-Удэд үзэсгэлэн дэлгэж мөн Дархан-Уул аймаг болон хөдөө орон нутгийн бүтээн байгуулалт, баримал тохижилтод сүүлийн 10 жил орчим гар бие оролцож буй СББӨ-ийн өвлөн уламжлагч юм.



Зураг 41-42. СББӨ-ийн өвлөн уламжлагч Д.Энхболд бүтээлээ дэлгэсэн нь.

Уламжлалт гар урлалын ай савын Модон сийлбэрийн урлал, Хөөрөг урлал зэрэг өвөөр Алтангадас одонт, МУСТА, СББӨ-ийн өвлөн уламжлагч Г.Эрдэнэтөгс оролцлоо.

Г.Эрдэнэтөгс нь уран дархан, сийлбэрээр 4 дэх үеийн өвлөн уламжлагч бөгөөд 45 дахь жилдээ гар урлалын бүтээлээ туурвиж байгаа юм. Түүний онцгой бүтээл бол мөнгөн эмээл болон Монголын анхны гурван толгойтой цахилгаан морин хуурийг урлаж соёлын өвд бүртгүүлсэн урлаач билээ.



Зураг 43-44. Соёлын биет өвийн өвлөн уламжлагч Г.Эрдэнэтөгс оролцсон нь.

Уламжлалт гар урлалын ай савын Эсгий хийх уламжлалт арга, Эсгий ширмэл урлалын өвөөр уран зургийн бүтээлээр Дархан сумын иргэн, Ардын авьяастан, СББӨ-ийн өвлөн уламжлагч Т.Жаргалсайхан оролцлоо.

Т.Жаргалсайхан нь 1998 оноос эхлэн ноос боловсруулж эсгий урлалын бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулж эхэлжээ. Монголын үндэсний урлал болон эсгий урлагийг хөгжүүлж, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр сүүлийн жилүүдэд сургалт зохион байгуулах, эсгий дээр дүрслэх урлалын бүх төрлийг хийх боломжийг судалж, нэвтрүүлж буй уран бүтээлч юм.



Зурагт 45-46. Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч Т.Жаргалсайхан нь бүтээлээрээ оролцсон нь

Уламжлалт гар урлалын ай савын уран хатгамал, оёдлын урлал, Зоос ширээ сүлжих урлалын өвөөр СББӨ-ийн өвлөн уламжлагч Ж.Батцэцэг нь оролцлоо.

Тэрээр эмээ, ээжээсээ өвлөн уламжлан 4 дэх үеийн өвлөн уламжлагч бөгөөд Уран хатгамлын чиглэлээр үзэсгэлэн арга хэмжээнд оролцон Дархан сумандаа сургалт зохион байгуулж өвлүүлэн уламжлуулж байгаа билээ.






Зураг 47-50. Соёлын биет өвийн өвлөн уламжлагч Ж.Батцэцэг бүтээлээрээ оролцсон нь

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн асар:

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн асрын зохион байгуулагчаар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар ажиллалаа.

Тус асарт 11 байгууллагын 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр иргэдэд үйлчилгээ үзүүлж 10.0 гаруй сая төгрөгийн борлуулалт хийлээ.

Оролцсон байгууллагууд “Дархан Нэхий” ХХК, “Эко ноос” ХХК, “Дарханд үйлдвэрлэв” ЖДҮ эрхлэгчид, “Согоон Урлан” оёдлын цех савхин эдлэл, “Дархан эсгий” хоршооноос эсгийгээр хийсэн бүтээгдэхүүн, “Амгаланзаяа” монгол тан, эмийн ургамал, “Домогт Шарын гол” ХХК-иас хусны нүүрс, саван, “Дархан хүнс” ХК-иас сүү, сүүн бүтээгдэхүүн, “Дархан өсөх ирээдүй” хоршоо цагаан идээ ааруул эзэгий, Орхон сумын иргэн Д.Амгалан урианхайн өв соёл, “Номадс” сүлжээ хоолны ресторан хоол үйлдвэрлэлээр тус тус амжилттай оролцлоо.





Зураг 51-56. Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид бүтээгдэхүүнээрээ оролцсон нь.



Зураг 57. “Нэхий” ХК монгол гэрийн цагаан эсгий дээврээр туслалцаа үзүүлж хамтран ажилласан нь.

ТАЙЖ ХАЙРХАНЫ БЭЛД “СЭРСЭН ТАЛ” ЭГШИГЛЭВ.

“НҮҮДЭЛЧИН” дэлхийн соёлын фестивалийн нээлтэд УГЗ Н.Буянбаатарын удирдлаган дор хөгжмийн зохиолч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, УГЗ, Төрийн шагналт Б.Шаравын “Сэрсэн тал” аялгууг тоглох 512 хөгжимчдийн бүрэлдэхүүнд Залуучууд театрын хөгжимчид болон соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчид, аймгийн Соёл, урлагийн газрын албан хаагчид, Орхон, Хонгор сумдын Соёлын төвийн дарга, ажилтнууд, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн зэрэг нийт 15 хөгжимчин оролцлоо.



Зураг 58-59. “Сэрсэн тал” эгшиглүүлэхэд Дархан-Уул аймгаас оролцсон бүрэлдэхүүн

ДАРХАНЫ ХҮҮ “ӨСВӨРИЙН БӨХИЙН БАРИЛДААН”-Д ТҮРҮҮЛЭВ

Тус фестивалийн үеэр үндэсний спортын 15 төрлийн уралдаан, тэмцээнийг зохион байгуулав. Тэдгээр тэмцээний нэг болох **16 нас хүртэлх насны “Өсвөрийн бөхийн барилдаан”**-д нийт 32 бөхийн барилдсанаас Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургуулийн сурагч Алтанхуягийн Сумъяабазар 5 давж түрүүллээ. А.Сумъяабазар нь Үндэсний их баяр наадмаар мөн үзүүлэж “Улсын шандас” цол хүртсэн өсвөрийн залуу бөх юм. Мөн Даваахүүгийн Зэлмэ хоёр давж дунд шөвөгт шалгарч СББӨ-ийн өвлөн уламжлагч Нямпүрэвийн Үйтүмэн амжилттай барилдлаа .

Өсвөрийн бөхийн барилдаанд түрүүлсэн болон амжилттай барилдсан хүүхдүүдэд ажлын хэсгийн дарга бөгөөд Засаг даргын орлогч Б.Жавхлан, Соёл, урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ нар баяр хүргэж тус бүр 50.000 төгрөг гардууллаа.





Зураг 60-63. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийн үеэр өсвөрийн бөхийн барилдаанд түрүүлж, амжилттай барилдсан бөхчүүдэд хүндэтгэл үзүүлсэн нь.

УЛАМЖЛАЛТ ТОГЛООМ НААДГАЙГ 1600 ГАРУЙ ХҮНД СУРТАЛЧЛАН ТАНИУЛАВ.

“Нүүдэлчин” дэлхийн соёлын наадамд аймгийн Музейн мэдээллийн ажилтан Б.Уранцэцэг Дархан-Уул аймгийн отогт Монголын ард түмний олон мянган жилийн турш бүтээсэн соёлын үнэт өвийн нэг ардын уламжлалт тоглоом наадгайн хөтөлбөрөөр оролцлоо.

Тус хөтөлбөрт Хорол, Чүү чамай, Тэмээн таваг, Дөрвөн бух, Шагайн наадгай зэрэг уламжлалт тоглоом найдгайг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав. Наадмын 3 өдөрт 620 насанд хүрэгч, 980 хүүхэд нийт 1600 гаруй хүнд үйлчиллээ.



Зураг 64-65. Ардын уламжлалт тоглоом наадгайгаар наадуулсан нь.

ҮНДЭСНИЙ ХУВЦАСНЫ ҮЗҮҮЛЭХ ТОГЛОЛТОД “ДОМОГ АМИЛСАН НУТАГ” БҮТЭЭЛЭЭР ОРОЛЦЛОО.

2023 оны 08 дугаар сарын 20-ны өдөр их тайзан дээр зохион байгуулсан Үндэсний хувцасны үзүүлэх тоглолтод Дархан хайрхан, Хараа голыг илэрхийлсэн загварын хувцсаар оролцлоо.

“Дархан” хархүү - Дархан нутгийн зон олны шүтлэгт уулыг бэлгэдэн Монгол дээлны загвар эсгүүрээр даавууг элдсэн арьстай хослуулан тоног товруу, төмөр металиар чимэглэн Дархан Хайрхан уулын сүрлэг бадрангуй дүрийг шингээн урласан. /Загвар өмсөгч Залуучууд театрын дуучин СТА Домбонгийн Бибиш/

“Хараа” бүсгүй - Дархан нутгийн зон олныг ундаалдаг “Хараа гол”-ыг бэлгэдэн Монгол үндэсний хувцасны хэв шинжийг хадгалан усны тунгалаг цэнхэр өнгийг цагаан өнгөтэй хослуулан усны хээ угалзаар чимэглэн уян тансаг эрхэмсэг энэрэнгүй сэтгэлт бүсгүйн дүрийг шингээн урласан юм. /Загвар өмсөгч Залуучууд театрын Дуучин Б.Шүрээ/

“Дархан хархүү” дүрийн хүүхэд нас /Загвар өмсөгч Оюуны ирээдүй Цогцолбор сургуулийн 1-9 ангийн сурагч Бибишийн Баянмөнх/

Загвар зохион бүтээгч: Залуучууд театрын зураач СТА, Гэгээн муза 2007 наадмын шилдэг зураач, Эмэгтэй зохион бүтээгчдийн олон улсын үзэсгэлэнгийн алтан медальт Гончигийн Хашцэцэг



Зураг 66-67. Үндэсний хувцасны үзүүлэх тоглолтын үеэр.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд сурталчлах чиглэлээр:


Нүүдэлчин дэлхийн соёлын наадмын удирдамж, зохион байгуулалт, байршил, явцын мэдээ мэдээллийг орон нутгийн DBS, RGB телевизүүд, Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын портал сайт <https://da.moc.gov.mn/> болон <https://www.facebook.com/profile.php?id=100091754469705> цахим сошиал хуудас, аймгийн Засаг даргын Тамгын газрын <https://www.facebook.com/Darkhan.ZDTG> цахим хуудсуудаар болон, Цэц.мн, Нутаг-21, Монцамэ агентлаг зэрэг цахим сайтуудад тухай бүр нийтэлж сурталчиллаа.

Тус соёлын фестивалд оролцсон соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчид болон оролцогчдын танилцуулга, мэдээллийг тусгайлан нийтэллээ. Тус наадамтай холбоотой нийт 107 мэдээ, постерийг нийтэлж иргэд олон нийтэд сурталчилсан байна.

Нүүдэлчин дэлхийн соёлын наадмын 3 өдрийн туршид Дархан-Уул аймгийн Хүндэтгэлийн гэрээр дамжуулан нүүдэлчин монголчууд, дарханчуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэн идээ ундаагаар үйлчлэн аймаг орон нутгаа сурталчилж ажилласан.

Дархан-Уул аймгийн оролцогчдыг дэмжиж УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, УИХ-ын гишүүн, Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр, Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал нарын удирдлагууд хүрэлцэн ирж отгийн үйл

ажиллагаануудад идэвхтэй оролцож соёлын биет бус өвийн өвлөн уламжлагдадаа амжилт хүссэн.



Зураг 68-72. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сошиалаар үйл ажиллагаагаа сурталчилсан нь.

Язгуур урлагийн их найман ханатай том гэрийг түрээсийн гэрээгээр, хүндэтгэлийн 6 ханатай гэрийг аймгийн ЗДТГ-аас, гар урлалын 6 ханатай гэрийг Хонгор сумын ЗДТГ-аас, хувцас солих, хоол цай бэлтгэх гэрийг Дархан сумын ЗДТГ-аас тус тус авч буцааж эвдрэл гэмтэлгүй хүлээлгэн өгсөн. Отогт шаардлагатай бусад эд хэрэгслийг Од цогцолбор сургууль, 6, 21 дүгээр цэцэрлэг, Дархан хотын соёл амралтын хүрээлэн, сумдын Соёлын төвүүд, Дархан Төмөрлөгийн үйлдвэр, Номадс ресторан зэрэг төр, хувийн хэвшлийн байгууллагуудаас авч ашигласан.

Фестивальд оролцогсдыг тээвэрлэх унааны асуудлыг аймгийн Авто тээврийн төв зохицуулж, Шар зам ирээдүй хоршооны зорчигч тээврийн автобусаар үйлчилж, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулсан.

Фестиваль зохион байгуулагдсан газрын талбай, отог, түр байрандаа эмх цэгцтэй, ахуйн ариун цэврийн шаардлагыг хангаж ажиллав. Тухайлбал: Гэмтэл осол, хулгай, галын аюулаас урьдчилан сэргийлэх, шатдаг хий бусад галын хэрэгсэлтэй харьцахдаа аюулгүй ажиллагааг чанд сахих, түлэгдэх, гэмтэх зэрэг ахуйн ослоос сэргийлэх, зөвшөөрөгдсөн тусгай цэгт тамхи татах, гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр байнга хяналт тавьж ажилласан. Аймгийн Онцгой байдлын газраас галын хор, элс, хүрз зэрэг багаж хэрэгслээр хангасан.

Отог бүр эмнэлгийн анхны шатны тусламж үзүүлэх хайрцагтай байх, шаардлагатай эм, эмийн хэрэгслийг бэлэн байлгах зааврын дагуу бэлтгэл бэлэн байдлыг бүрэн хангаж ажилласан. Фестивалийн үеэр оролцогчдын эрүүл мэнд муудаж, эмнэлгийн анхан шатны болон түргэн тусламжийн үйлчилгээ авсан тохиолдол гараагүй болно.

“Байгальд ээлтэй-соёл” нэрийн дор фестивалийн отог байрласан талбайн хог хаягдлыг тухай бүр нь түүж цэвэрлэн хоггүй, цэвэр орчныг бүрдүүлж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой, сөрөг нөлөөллийг бууруулахад онцгой анхаарч оролцсон. Арга хэмжээ дууссаны дараа орчин тойрноо цэвэрлэж, байгалийг эх төрх байдлаар нь үлдээлээ.



Зураг 73-74. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль зохион байгуулагдсан газарт байрласан отгийн гадна орчныг цэвэрлэж, гэр, эд зүйлсээ ачиж байгаа нь. /2023.08.21/

Төсөв, санхүүгийн асуудлыг шийдвэрлэсэн байдал:

Соёлын Сайдын 2023 оны А/257 дугаар тушаалаар 10,000,000 төгрөг, Монгол Улсын Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2023 оны А/24 дугаар тушаалаар 12,800,000 төгрөг буюу нийт 22,800,000 төгрөгийн санхүүжилтийг үзүүлсэн ба зардлыг зориулалтын дагуу зарцуулсан болно.

Тус газраас санхүүгийн тайланг 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 246 тоот албан бичгээр МУЗГ-ын Хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт цахимаар илгээж, цаасаар албажуулан хүргүүлсэн.

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ
БӨГӨӨД АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА

Б.ЖАВХЛАН

ТАЙЛАГНАСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН ХЭСГИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Х.СОЁЛ-ЭРДЭНЭ